



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

“Алтан тариа” ХХК-ийн үнэт  
цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Монгол Улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2011 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Алтан тариа” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 494,000 /дөрвөн зуун ерэн дөрвөн мянга/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Алтан тариа” ХХК-ийн хувийн хэрэг, холбогдох нотлох баримтыг журмын дагуу архивд шилжүүлэн хадгалуулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000174